

МОНГОЛ УЛС
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ
ТОГТООЛ

2003 оны 04 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар
хот

Журам батлах, зарим тогтоолыг
хүчингүй болгох тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3-д заасныг үндэслэн Үнэт цаасны хорооноос
ТОГТООХ нь:

1. “Харилцагчийн захиалгыг хүлээн авах, биелүүлэх тухай журам”, ~~“Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгүүлэх зөвшөөрөл олгох, түүнд өөрчлөлт оруулах, бүртгэлээ хасах, сурталчлах тухай журам”~~ /Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 37 дугаар тогтоолоор хүчингүй/ -ыг хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан журам батлах тухай Хорооны доорх тогтоолыг хүчингүйд тооцсугай.

2.1. “Харилцагчийн захиалгыг хүлээн авах, биелүүлэх журам” батлах тухай 1997 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 26 дугаар тогтоол;

2.2. “Нийтэд санал болгож гаргах үнэт цаасыг бүртгүүлэхийг зөвшөөрөх тухай журам” батлах тухай 1999 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 70 дугаар тогтоол;

2.3. “Монгол улсын үнэт цаасны зах зээл дээр худалдахаар зөвшөөрсөн үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх тухай журам” батлах тухай 1999 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 75 дугаар тогтоол;

2.4. “Нийтэд санал болгон компаниас өрийн бичгийг гаргах, бүртгүүлэх журам” батлах тухай 2001 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 35 дугаар тогтоол;

2.5. “Үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд өөрчлөлт оруулах тухай журам” батлах тухай 2001 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 37 дугаар тогтоол.

3. Шинээр батлагдсан журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Ж.Жадамбаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.ГҮНДЭНБАЛ

Үнэт цаасны хорооны 2003 оны 4 дүгээр
сарын 25-ны өдрийн 33 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ХАРИЛЦАГЧИЙН ЗАХИАЛГЫГ ХҮЛЭЭН АВАХ, БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар харилцагчаас өгсөн үнэт цаас худалдах, худалдан авах захиалгыг хүлээн авах, биелүүлэх талаар зуучлагч Брокер, дилерийн компани, түүний ажилтнаас явуулах үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьцаа эзэмшсэн этгээд үнэт цаасны хоёрдахь зах зээлд оролцохын өмнө анх зуучлуулсан Брокер,дилерийн компаниар дамжуулан үнэт цаасны төвлөрсөн хадгаламжинд /цаашид “төвлөрсөн хадгаламж” гэх/ заавал данс нээлгэсэн байна.

1.3. Төвлөрсөн хадгаламжид данс нээлгэсэн харилцагч өөрийнхөө эзэмшилд буй үнэт цаасаа худалдах болон үнэт цаас худалдаж авах захиалгын гэрээ байгуулах Брокер,дилерийн компаниа өөрөө сонгоно.

1.4. Харилцагчаас захиалгын гэрээг зохих журмын дагуу үйлдээгүй, эсхүл биелүүлэх боломжгүй нөхцөл шаардсан захиалга байвал уг захиалгыг брокер хүлээн авахаас татгалзаж болно. Ийнхүү захиалгыг хүлээн авахаас татгалзсан үндэслэл бүхий хариуг харилцагчид бичгээр өгнө.

1.5. Харилцагч өөрийн итгэмжилсэн этгээдээр, эсхүл Брокер,дилерийн компанийн албан ёсны зуучлагчаар дамжуулан үнэт цаас худалдах, худалдан авах захиалга өгч болно. Харилцагч итгэмжилсэн этгээдтэй Иргэний хуульд заасны дагуу итгэмжлэлийн гэрээ байгуулсан байна. Уг гэрээнд талуудын эрх үүрэг,хүлээх хариуцлагыг тодорхой тусгана.

1.6. Үнэт цаасны тухайн өдрийн ханшийг харгалзахгүйгээр худалдан авах захиалга тус бүрийн үнээр худалдаж болох зарчмаар биелүүлэх захиалгыг үнэт цаасыг худалдах зах зээлийн захиалга гэнэ.

1.7. Үнэт цаас худалдах захиалгын үнийн доод хэмжээг, худалдан авах захиалгын үнийн дээд хэмжээг заасан захиалгыг үнийн хязгаарлалттай захиалга гэнэ.

ХОЁР. Харилцагч төвлөрсөн хадгаламжид
данс нээлгэх, түүнд холболт хийлгэх, хэд
хэдэн брокер,дилерийн компаниар зуучлуулах

2.1. Төвлөрсөн хадгаламжид данс нээлгэсэн харилцагч үнэт цаас худалдах буюу худалдан авах захиалгыг анхдагч зах зээлд зуучилсан Брокер, дилерийн компаниас өөр компанид өгвөл өмнө нь Брокер, дилерийн бусад компанид нээлгэсэн бүх дансыг хаалгах хүсэлтээ захиалгын гэрээнд тусгана.

2.2. Брокер,дилерийн компанид шинээр данс нээлгэж, өмнөх дансаа хаалгахыг хүссэн харилцагчийн захиалгыг шинэ данс нээх, хуучин дансыг хаах ажлыг гүйцэтгэсний дараа дилерийн даалгаварт тусгана.

2.3. Харилцагч өөрийн өмчлөлийн үнэт цаасыг худалдахаар анхдагч зах зээлд зуучилсан Брокер, дилерийн компаниас бусад компанитай захиалгын гэрээ байгуулбал өмнөх холболтын дансыг заавал хаалгасан байна.

2.4. Аль нэгэн Брокер, дилерийн компаниар зуучлуулан үнэт цаасаа худалдахаар захиалга өгсөн харилцагч үнэт цаасаа бусад Брокер, дилерийн компаниар зуучлуулан худалдахыг хүсвэл өмнө нь байгуулсан захиалгын гэрээг цуцалсны дараа дараагийн гэрээг байгуулна.

2.5. Харилцагч өмчилж байгаа үнэт цаасаа хэд хэдэн Брокер, дилерийн компаниар зуучлуулан худалдахыг хүсвэл төвлөрсөн хадгаламж дахь дансанд байгаа үнэт цааснаасаа худалдах үнэт цаасны тоо, ширхгийг захиалгын гэрээ тус бүрт тодорхой тусгахын зэрэгцээ бусад Брокер, дилерийн компанитай байгуулсан захиалгын гэрээнд худалдахаар тусгасан үнэт цаасны тоо, ширхгийн талаар тухайн брокерт үнэн зөв мэдээлнэ.

2.6. Харилцагч Брокер, дилерийн бусад компанитай захиалгын гэрээ байгуулж, холболтын данс нээлгэхдээ өмнө нээлгэсэн дансанд оруулсан мөнгөний тухайн үеийн үлдэгдлийн хэдэн хувиар нь хичнээн ширхэг үнэт цаас худалдан авахыг уг захиалгын гэрээнд тусгана.

2.7. Харилцагч хэд хэдэн Брокер, дилерийн компанитай үнэт цаас худалдан авах захиалгын гэрээг нэгэн зэрэг байгуулж, төвлөрсөн хадгаламжинд нээлгэсэн мөнгөний данстай холболтын данс нээлгэхийг хүсвэл дансанд байгаа мөнгөө захиалгын гэрээ тус бүрд өөрийн сонголтоор хувааж байршуулна.

2.8. Холболтын дансаар үнэт цаас худалдан авах захиалгын гэрээг биелүүлэх явцад харилцагчийн дансанд шинээр нэмж оруулсан мөнгийг өмнө хийсэн захиалгын гэрээг биелүүлэхэд зарцуулахгүй бөгөөд уг захиалгыг биелүүлсний дараа дахин захиалгын гэрээ байгуулж, дансанд шинээр байршуулсан мөнгийг зарцуулна. Шинээр байгуулсан гэрээний хүчин төгөлдөр болох хугацааг тухайн мөнгийг дансанд оруулсан он, сар, өдөр, цаг минутаар тогтооно.

2.9. Харилцагч холболтын дансаар үнэт цаас худалдан авахаар Брокер, дилерийн компани тус бүртэй байгуулсан захиалгын гэрээний биелэлтийг тус тусад нь дүгнэнэ.

ГУРАВ. Брокер харилцагчтай захиалгын гэрээ байгуулах

3.1. Захиалгын гэрээ байгуулж буй брокер захиалга өгөх, түүнийг биелүүлэхтэй холбогдох хууль, журмын талаар болон харилцагчийн эрх үүргийн талаар тухайн харилцагчид зөвлөгөө, зааварчилга өгөх үүрэгтэй.

3.2. Харилцагчаас өгсөн үнэт цаас худалдах буюу худалдан авах зах зээлийн захиалгыг үнэ ханшийн аливаа нөхцөл заахгүйгээр брокер хүлээж авна. Тухайн төрлийн захиалгыг харилцагчаас хүлээж авахдаа брокер захиалгын гэрээний маягтын “нэгжийн үнэ” гэсэн мөрөнд бичилт хийхгүй.

3.3. Зах зээлийн захиалгаас бусад бүх төрлийн захиалгыг хүлээж авахдаа брокер худалдах захиалгын хувьд үнийн доод хэмжээ, худалдан авах захиалгын хувьд үнийн дээд хэмжээг харилцагчтай заавал тохиролцон захиалгын гэрээнд тусгасан байна.

3.4. Энэ журмын дагуу байгуулсан захиалгын гэрээний хоёр хувийг харилцагчаас, эсхүл түүний итгэмжлэгдсэн этгээд буюу анхан шатны зуучлагчаас нь брокер хүлээн авч, баримтын бүрдүүлэлтийг шалгаж, холбогдох бичилт хийж, хувийн тэмдэг дарж, гарын үсэг зурсан он, сар, өдөр, цаг минутаас эхлэн уг захиалгын гэрээ хүчин төгөлдөр болно.

Дээр дурдсан ажилбарын аль нэгийг дутуу үйлдсэн захиалгын гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

3.5. Үнэт цаас худалдах захиалгын гэрээний хүчин төгөлдөр байх хугацаа ажлын 78 хоног, худалдан авах захиалгын гэрээний хүчин төгөлдөр байх хугацаа ажлын 26 хоног байна.

3.6. Захиалгын гэрээ байгуулсны дараа гэрээнд заасан үнэт цаас худалдан авахаар харилцагчийн дансанд оруулсан мөнгө уг гэрээний нөхцөлд хамаарахгүй.

3.7. Харилцагч үнэт цаас худалдах, эсхүл худалдан авах захиалгын гэрээ байгуулах хугацааны дарааллыг брокерт утсаар өгч болно. Уг харилцагч ажлын 2 хоногийн дотор брокертой уулзаж захиалгын гэрээгээ байгуулаагүй бол өмнө тохиролцсон хугацааны дарааллыг хүчингүйд тооцно.

3.8. Брокер захиалгын гэрээ байгуулах талаар харилцагчаас утсаар хүлээж авсан мэдээллийг тусгай дэвтэрт тэмдэглэж, түүнийг Брокер, дилерийн компанийн менежерт заавал танилцуулсан байна.

ДӨРӨВ. Харилцагчийн захиалгыг биелүүлэх ажиллагаа

4.1. Харилцагчаас хүлээн авсан үнэт цаас худалдах, худалдан авах захиалгыг брокер Улаанбаатар хотод дараа өдөр, орон нутагт 3 хоногт багтааж дилерийн даалгаварт үнэн зөв тусгуулж, дилерт шилжүүлснээр уг захиалгыг биелүүлэх үйл ажиллагаа эхэлнэ.

4.2. Үнэт цаас худалдах зах зээлийн захиалгыг тухайн үнэт цаасны эрэлтийн хэмжээгээр, худалдан авах зах зээлийн захиалгыг тухайн үнэт цаасны нийлүүлэлтийн хэмжээгээр биелүүлнэ.

4.3. Харилцагч өөрийн захиалгыг тухайн үнэт цаасны арилжааны явцад биелүүлэхгүй байх талаар арилжааны брокерт мэдэгдсэн тохиолдолд уг захиалгыг биелүүлэхгүй бөгөөд энэ талаар дилерийн даалгаварт тэмдэглэнэ. Тухайн өдөрт нь багтааж анх захиалга авсан брокерт энэ талаар мэдэгдэнэ.

4.4. Зах зээлийн захиалгын гэрээг биелүүлэх явцад харилцагч гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах тухай хүсэлтээ арилжааны брокерт утсаар гаргаж болно. Энэ нөхцөлд арилжааны брокер захиалгыг биелүүлэхгүй бөгөөд харилцагч гэрээгээ брокертой шинэчлэн байгуулна. Гэхдээ шинэчлэн байгуулсан гэрээний хүчин төгөлдөр байх хугацааг өмнөх гэрээний үлдсэн хугацаагаар тогтооно.

4.5. Үнийн хязгаарлалттай захиалгын гэрээ байгуулсан харилцагч захиалга нь дилерийн даалгаварт тусгагдсанаас хойш үнийн хязгаарт өөрчлөлт оруулах хүсэлтээ арилжааны брокерт гаргаж болно.

4.6. Үнэт цаас худалдан авах болон худалдах ижил нөхцөлтэй захиалгыг үнийн дээд доод хэмжээг үндэслэн, тэнцүү тохиолдолд хугацааны дарааллаар тус тус биелүүлнэ.

4.7. Хэрэв харилцагч хүсвэл арилжааны брокертой утсаар ярихад хэрэглэдэг нууц паролтой байж болно.

4.8. Харилцагч өөрийн захиалгыг биелүүлэх явцад захиалгын гэрээгээ цуцлахыг хүсвэл энэ тухай арилжааны брокерт мэдэгдэж, дилерийн даалгаварт тэмдэглэл хийлгэнэ.

4.9. Захиалгын гэрээг биелүүлэх явцад харилцагч уг гэрээнд тусгасан үнэт цаасны үнэ ханш, дансны хуулга, хэлцлийн тасалбар, гүйлгээний мэдээтэй холбогдсон асуудлаар арилжааны брокертой харилцана.

4.10. Үнэт цаасны арилжаа явагдсаны дараа арилжааны брокер хэлцлийн тасалбар, харилцагчийн дансны хуулгыг захиалга авсан брокерт шилжүүлнэ.

4.11. Үнэт цаасаа худалдах харилцагчийн хувьд захиалгын гэрээнд тусгасан үнэт цаасны тоо, ширхгийг хорогдуулах хүсэлтээ зохих журмын дагуу брокерт тавьж, захиалгын гэрээнд өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд уг гэрээг хүлээн авсан хугацааг түүнд өөрчлөлт оруулсан он, сар, өдөр, цаг минутаар шинэчлэн тогтооно.

ТАВ. Харилцагчийн захиалгын гэрээг дуусгавар болгох, цуцалсанд тооцох

5.1. Харилцагчтай байгуулсан захиалгын гэрээг дараахь тохиолдолд дуусгавар болсонд тооцно:

5.1.1. Захиалгын гэрээнд дурдсан үнэт цаас худалдах, эсхүл худалдан авах захиалгыг бүрэн биелүүлсэн;

5.1.2. Захиалгын гэрээнд тусгасан үнэт цаасыг худалдан авахад зориулсан харилцагчийн дансанд байгаа мөнгө дууссан;

5.1.3. Захиалгын гэрээний үйлчлэх хугацаа дууссан.

5.2. Харилцагчтай байгуулсан захиалгын гэрээг дараахь тохиолдолд цуцалсанд тооцно:

5.2.1. Харилцагчаас брокерт болон арилжааны брокерт захиалгын гэрээг цуцлах тухай хүсэлт гаргасан;

5.2.2. Харилцагч үнэт цаасны 5 удаагийн арилжааны явцад өөрийн захиалгын гэрээг биелүүлэхгүй байхыг хүссэн тохиолдолд үнэт цаасны арилжаанд оролцохоос татгалзсан сүүлчийн өдрөөр тасалбар болгон;

5.2.3. Тухайн үнэт цаасны арилжаа гүйлгээтэй холбогдох өргөдөл, гомдлын дагуу Үнэт цаасны хороо болон шүүхээс захиалгын гэрээг цуцлах тухай шийдвэр гаргасан.

5.3. Харилцагч захиалгын гэрээгээ цуцлах хүсэлтээ брокерт амаар/утсаар/, бичгээр гаргаж болно.

5.4. Харилцагч захиалгын гэрээг дуусгавар болгох, эсхүл түүнийг цуцалсанд тооцсон тохиолдолд харилцагч болон захиалгын гэрээ байгуулсан брокер доорхи ажилбарыг хийж гүйцэтгэнэ:

5.4.1. Харилцагч захиалгын гэрээг цуцлах тохиолдолд брокертой биечлэн уулзаж, захиалгын гэрээний брокерт байгаа хувь дээр “цуцлав” гэж бичиж, гарын үсгээр баталгаажуулан брокерт хүлээлгэж өгнө. Брокер цуцалсан захиалгын гэрээг компанийнхаа бичиг хэрэгт шилжүүлнэ;

5.4.2. Харилцагч захиалгын гэрээний өөрт байгаа хувь дээр түүнийг цуцлах тухай хүсэлтээ тэмдэглэж, гарын үсэг зурж баталгаажуулан брокерт хүргүүлж болно. Уг гэрээг байгуулсан брокер буюу захиалга авсан Брокер, дилерийн компанийн холбогдох ажилтан харилцагчийн бичгээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авахдаа захиалгын гэрээний уг хувийг хүргэж ирсэн этгээдийн биеийн байцаалтыг /иргэний үнэмлэх, эсхүл ажлын газрын үнэмлэх/ шалгаж, харилцагчаас бичгээр ирүүлсэн хүсэлтийг хүлээж авсан он, сар, өдөр, цаг минутыг брокерт байсан захиалгын гэрээний хувь дээр тэмдэглэж, гарын үсэг зурж баталгаажуулна. Мөн брокер захиалгын гэрээн дээр бичсэн тэмдэглэлийг үндэслэн захиалгын гэрээний бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хийж, уг гэрээг архивт хадгалуулахаар компанийнхаа бичиг хэрэгт шилжүүлнэ;

5.4.3. Харилцагч, брокер, итгэмжлэгдсэн этгээд болон анхан шатны зуучлагчийн хооронд байгуулсан захиалгын гэрээг дуусгавар болгосонд тооцсон тохиолдолд захиалгын гэрээ, гэрээ дүгнэсэн акт, дансны хуулга зэрэг холбогдох баримт материалыг Брокер, дилерийн компанийн бичиг хэрэгт хадгална;

5.4.4. Харилцагч захиалгын гэрээг цуцлах тухай хүсэлт гаргасан, эсхүл үнэт цаасны арилжаанд оролцохоос удаа дараа/3-аас дээш удаа/ түдгэлзсэн, Үнэт цаасны хорооны

болон шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд уг шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 5 хоногт багтаан харилцагч брокер хоёр гэрээг дүгнэж, холбогдох тооцоог хийж дуусгавар болгон баримтыг Брокер, дилерийн компанийн бичиг хэрэгт шилжүүлнэ.

ЗУРГАА. Брокер, харилцагчид хориглох үйл ажиллагаа

6.1. Харилцагчийн захиалгыг хүлээн авч биелүүлж буй брокерт “Үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчээс үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааны тухай журам”-ын 4.3-д зааснаас гадна дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

6.1.1. Харилцагчид захиалгын гэрээний биелэлтийг танилцуулах болон дансны хуулгыг гаргаж өгөхөөс татгалзах;

6.1.2. Харилцагч тухайн Брокер, дилерийн компанид шинээр данс нээлгэх, өмнө нь нээлгэсэн бусад дансыг хаалгах хүсэлт гаргасан тохиолдолд данстай холбогдох асуудлыг эцэслэн шийдвэрлээгүй байхад харилцагчийн захиалгыг биелүүлэх;

6.1.3. Харилцагчаас брокерт өмнө нь өгсөн үнэт цаас худалдах, худалдан авах захиалгыг биелүүлэхгүй байх талаар мэдэгдсэн нөхцөлд түүний захиалгыг биелүүлэх;

6.1.4. Арилжааны бус хэлцлээр худалдсан эсхүл худалдаж авсан үнэт цаасыг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын арилжаанд давхар оруулах;

6.1.5. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр тухайн үнэт цаасыг өмчилсөн этгээдээс арилжааны бус хэлцлээр үнэт цаасыг худалдаж авсан батламжид/гэрээнд/ даалгаврын гэрээг хавсаргаагүй тохиолдолд Маягт №А5-6-гаар үйлдсэн тодорхойлолт гаргах.

6.2. Брокер, дилерийн компанид үнэт цаас худалдах, худалдан авах захиалга өгч зуучлуулж байгаа харилцагчид дараахь үйлдэл хийхийг хориглоно:

6.2.1. Тухайн Брокер, дилерийн компаниар зуучлуулж байгаа бусад харилцагчийн талаар мэдээлэл авах зорилгоор менежер, брокер, арилжааны брокер, холбогдох бусад ажилтанд хувийн эрх ашгийн үүднээс шахалт, дарамт үзүүлэх, ятгах;

6.2.2. Захиалгын гэрээг биелүүлэх явцад түүнийг шинэчлэн байгуулах шаардлага тавих;

6.2.3. Захиалгын гэрээ байгуулах, цуцлахад холбогдох хууль, журам, заавар зөрчсөн үйлдэл хийх;

6.2.4. Тухайн үнэт цаасыг худалдах захиалгыг Брокер дилерийн хэд хэдэн компанид давхардуулан өгөх;

6.2.5. Эзэмшиж буй дотоод мэдээллийг бусдад дамжуулах;

6.2.6. Үнэт цаасны арилжаанд оролцож байгаа харилцагч уг захиалгыг биелүүлэхэд үнэ ханшид нөлөөлөх аливаа үйлдэл хийх;

6.2.7. Холболтын дансаар үнэт цаас худалдан авч байгаа харилцагч Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын гишүүн Брокер дилерийн нийт компанийн тавны нэгээс илүү тооны компанид холболтын данс нээлгэх.

ДОЛОО. Журмын биелэлтэд хяналт тавих, хүлээлгэх хариуцлага

7.1. Энэхүү журмын биелэлтэд Брокер дилерийн компанийн менежер, Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын хяналтын албаны ажилтан, Үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагч хяналт тавина.

7.2. Журмын заалтыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан захиргааны шийтгэл ногдуулна.